

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

ОЙЖУУЛАЛТЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Захиалагчийн нэр: Хөвсгөл аймгийн Засаг дарга

Тендерийн нэр: Ойжуулалт хийх ажлын гүйцэтгэгч сонгох

Тендерийндугаар: **ХӨАОНӨГ/202012077.4.2.1**

Батлав: Хөвсгөл аймгийн Засаг дарга...../Л.Ганболд/

Хянасан: Аймгийн орон нутгийн
өмчийн газрын дарга/Б.Болд/

Танилцсан: Аймгийн Байгаль орчин аялал
Жуулчлалын газрын дарга/Р.Жаргалсайхан/

Боловсруулсан:

Үнэлгээний хорооны дарга: /Х.Хадбаатар /

Гишүүд: /Ч.Лхагвамядаг/

/Х.Болд-Эрдэнэ/

/Ч.Уртнасан /

Нарийн бичгийн дарга: /Д.Төмөр /

Мөрөн хот

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020.01.21

Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны алба нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос *Ойжуулалт хийх ажил*-ийг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF) файлаар илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 mb, нэг файлын хэмжээ 15 mb байна. Цахим тендер зохион байгуулалт, журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 /тавин мянган/ төгрөгийг www.tender.gov.mn -ээр банкны е-меркантийн системийг ашиглан төлнө. Үнийн санал ирүүлэх материалын техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн санал ирүүлэх материалын техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг *2019 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 11 цаг 00 минут*-аас өмнө *Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын “А” байр, 1 давхар, худалдан авах ажиллагааны ил тод байдлын танхимд утас: 70388849, 70388848, 70388821, факс: 70388849, (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн Д.Төмөр)* хаягаар ирүүлнэ..

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан *2019 оны 1 дүгээр сарын 29-ний -ний өдрийн 11 цаг 20 минут*¹-т нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх. Тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг,
Орон нутгийн өмчийн газар,
аймгийн ЗДТГ-ын А байр, 114 тоот өрөө,
утас: 70388848, 70388821, 95490203, факс: 70388849**

¹ Тендерийг хүлээж авах эцсийн хугацааг дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
**Шаардлагатай
Ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн эрхтэй байна**
 - (д) Голлох инженер техникийн ажилтнуудын танилцуулга.
 - (ё) бусад...
4. **Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
5. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. **Алдааг залруулах**
 - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
 - (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;

- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	А.Шалгуур																																					
1.0	<p>Тендер шалгаруулалтын нэр, дугаар: Ойжуулалт хийх ажил ХӨАОНӨГ/202012077.4.2.1</p> <p><i>Санхүүжилтийн эх үүсвэр: Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал</i></p> <p>Нийт батлагдсан төсөвт өртөг 15,000,000 төгрөг 2019 онд олгох санхүүжилтийн хэмжээ- 15,000,000 төгрөг</p> <p>Захиалагчийн нэр: Хөвсгөл аймгийн засаг дарга</p>																																					
1.1	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-16 дугаар зүйл буюу тендерт оролцогч гэрээ хэрэгжүүлэх чадвартайгаа нотолж тендерт ирүүлэх чадварын мэдээллүүд: Үүнд:</p> <p>1.Сүүлийн 1 буюу 2018 оны жилийн санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх</p> <p>2. Сүүлийн 1 жилийн туршлагын мэдээлэл /"Ойжуулалтын ажил"-тай ижил төрлийн ажил нийлүүлж байсан гэрээний тухай мэдээлэл/-ийг дараах хүснэгтээр ирүүлнэ:</p> <table border="1" data-bbox="518 967 1455 1178"> <thead> <tr> <th rowspan="2">№</th> <th rowspan="2">Гэрээний нэр</th> <th rowspan="2">Барааны нэр</th> <th rowspan="2">Гэрээний үнэ /мян.төг/</th> <th colspan="3">Захиалагчийн мэдээлэл</th> </tr> <tr> <th>нэр</th> <th>хаяг</th> <th>Утасны дугаар</th> </tr> </thead> <tbody> <tr> <td> </td> <td> </td> <td> </td> <td> </td> <td> </td> <td> </td> <td> </td> </tr> <tr> <td> </td> <td> </td> <td> </td> <td> </td> <td> </td> <td> </td> <td> </td> </tr> <tr> <td> </td> <td> </td> <td> </td> <td> </td> <td> </td> <td> </td> <td> </td> </tr> </tbody> </table> <p>Дээрх мэдээллийн хамт өмнөх захиалагчтай байгуулсан гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт, гэрээний хэрэгжилтийн үр дүнгийн талаар өмнөх бүх захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ.</p> <p>3.Тайлан ирүүлсэн жилд ашигтай ажилласан байна.</p> <p>4. Сүүлийн 1 жилд санал захиалагчийн санал болгож буй төсөвт өртгийн 100 хувь түүнээс дээш хэмжээний борлуулалтын орлоготой байсныг нотлох баримт бичиг /санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт/</p> <p>5. Сүүлийн 2 жилийн аль нэг жилд нь захиалагчийн санал болгож буй төсөвт өртгийн 100 хувиас доошгүй өртөгтэй ойжуулалтын ажлыг гэрээгээр гүйцэтгэж байсан туршлагатай байх</p> <p>6. Хугацаа хэтэрсэн өр төлбөртэй эсэх талаар татвар, нийгмийн даатгал, харилцах банк, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын тодорхойлолтууд ирүүлнэ.</p> <p>Тодорхойлолтууд нь гаргаснаас хойш 1 сарын дотор хүчинтэй байна. Татвар, хураамж, төлбөрөө төлсөн эсэхийг тендер нээсэн өдрөөр тооцно. Татвар, нийгмийн даатгал, банк, бусад байгууллагад хугацаа хэтэрсэн өр төлбөртэй, ял шийтгэлтэй болох нь холбогдох байгууллагуудаас ирүүлсэн тодорхойлолтоор нотлогдсон тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>7. Тендерт оролцогч олон багц ажлын тендерт оролцох болон хэрэгжүүлж байгаа буюу хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл, тус гэрээнд ажиллаж байгаа, ажиллуулах голлох инженер, техникийн ажилтан, ажилчид, машин механизм, багаж хэрэгслийг танилцуулах бөгөөд тэдгээр нь санал болгож буй тендерийн саналтай давхардсан тохиолдолд уг ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болно. Хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэх эрх авсан гэрээний хугацаа, өртөг, захиалагчийн албан ёсны хаяг, байршил, харилцах утасны дугаарын талаарх мэдээллийг ирүүлнэ.</p>							№	Гэрээний нэр	Барааны нэр	Гэрээний үнэ /мян.төг/	Захиалагчийн мэдээлэл			нэр	хаяг	Утасны дугаар																					
№	Гэрээний нэр	Барааны нэр	Гэрээний үнэ /мян.төг/	Захиалагчийн мэдээлэл																																		
				нэр	хаяг	Утасны дугаар																																

8. Тендерт оролцогчийн санал болгосон нийт инженер техникийн ажилтан, ажилчдын 50-аас доошгүй хувь нь өөрийн компанийн үндсэн ажилтан, ажилчид байна. Компанийн үндсэн ажилтан, ажилчдын НДШ-ийг компаниас төлсөн болохыг НД-ын байгууллагын НД№7, НД№8 маягтаар гаргасан тодорхойлолт лавлагаа, ажилтны нийгмийн даатгалын дэвтэрийн нотариатаар батлуулсан хуулбарыг тус тус үндэслэн тогтооно.

Тухайн тусгай зөвшөөрөлд дурьдсан эсвэл тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэхэд шаардлагатай инженер техникийн ажилтнууд, мэргэжилтэн, мэргэжилтэй ажилчдын мэргэжлийн бэлтгэл, туршлагыг захиалагчаас тогтоосноор дараах хүснэгтээр ирүүлнэ. Үүнд:

Албан тушаал	Мэргэжил, боловсрол	Хүний тоо	Мэргэж-лээрээ ажилласан жилийн тоо	НД-ийн дэвтэрийн дугаар
Ойн инженер	Ойн инженер	1	3-аас доошгүй	
Туслах ажилчид	Ойн мэргэжлийн ажилтан	2	1 ба түүнээс дээш	

Энэ хүснэгтэд заасан ИТА, мэргэжилтэй ажилчдын иргэний үнэмлэх, диплом, мэргэжлийн үнэмлэх, нийгмийн даатгалын дэвтэр зэрэг баримт бичгийн эх хувиас татсан хуулбарыг тендерт ирүүлнэ. Дээрхи хүснэгтэд заасан ИТА нь тендерт оролцогчийн үндсэн ажилчин байна.

9. Гэрээт ажилд ашиглах доорх хүснэгтэд дурьдсан машин механизм, тоног төхөөрөмжийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбарыг нотариатаар баталгаажуулж ирүүлнэ. Машин тоног төхөөрөмж нь компанийн өөрийн эзэмшлийнх байна. Үүнд:

Машин тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нэр, зориулалт	Тоо, хэмжээ	Улсын бүртгэлийн гэрчилгээ, техникийн паспортын дугаар	Эзэмшдэг байгууллага иргэний нэр	Чанар байдал, ашиглалтад орсон огноо
Колесовын жоотуу	5 ширхэг			
1 тонны усны сав	1 ширхэг			
Хүрз	10 ш			
Царил	10 ш			

10. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: Тендерт оролцогчийн иүүлсэн үнийн саналын 30%-иас багагүй байх

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийг аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр нь тодорхойлно.
-Байгууллагын харилцах банкин дахь дансны үлдэгдэл /банкны тодорхойлолт, даныны хуулгаар тодорхойлно./

-Арилжааны банкнаас зээл олгох бололцоотой болохыг нотлох тодорхойлолт

11.Улсын бүртгэлийн гэрчилгээний эх хувиас татсан хуулбарыг нотариатаар батлуулж ирүүлнэ.

12.Тухайн бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөл шаардлагатай

	<p>эсэхийг зааж, тусгай зөвшөөрлийн дугаар, заалтыг нэг бүрчлэн бичнэ. Үүнд:</p> <p>-Байгал орчны яамнаас олгосон ойжуулалтын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй байх /тусгай зөвшөөрөл нь уг ажлыг гүйцэтгэж дуусах хүртэл хүчин төгөлдөр байна/ 13. Аж ахуйн нэгжийн талаарх танилцуулга мэдээллийг гаргаж ирүүлнэ.</p> <p>14. Ойжуулалтын болон нөхөн сэргээлтийн ажилд шаардлагатай “шинэс” модны 2-3 настай тарьцны нөөцтэй болохыг холбогдох мэргэжлийн төрийн байгууллагаар тодорхойлуулсан баримт бичиг</p> <p>15. Тендерт оролцогч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийг зөрчсөн нөхцөл бүхий тендер ирүүлсэн оролцогчийн тендерээс татгалзана.</p> <p>16. Санал болгосон тарьц нь MNS 6140:2010 стандартын шаардлага хангасан байна.</p> <p>17. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр ирүүлэх. /Тендерт оролцогч нь үнэлгээний хорооны гишүүдэд нөлөөлөх, нөлөөлөхийг оролдсон нь баримтаар нотлогдвол тендерээс татгалзана./</p> <p>18. Бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх үе шатны болон санхүүжилтийн хуваарийг заасан маягтаар захиалагчийн санал болгосноор боловсруулан тендерт оролцогчийн эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулж ирүүлэх.</p> <p>19. Захиалагчийн санаачлагаар Шүүх, харилцагчбанк, Эрүүл мэнд нийгмийн даатгалын газар, Оюуны өмч, улсын бүртгэлийн газар, татварын хэлтэс, өмнө үйлчлүүлсэн захиалагчаас болон бусад холбогдох байгууллагаас тендерийн бичиг баримттай холбоотой асуудлаар тодорхойлолт, лавлагаа авахад татгалзах зүйлгүй гэсэн агуулга бүхий мэдэгдлийг тендерт оролцогч баталгаажуулан өөрийн тендерийн баримт бичигт хавсарган ирүүлнэ.</p> <p>20. Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн <i>итгэмжлэлийг ирүүлэх.</i></p> <p>21. Тендерт оролцогч олон багц ажлын тендерт оролцох болон хэрэгжүүлж байгаа буюу хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл, тус гэрээнд ажиллаж байгаа, ажиллуулах голлох инженер, техникийн ажилтан, ажилчид, машин механизм, багаж хэрэгсэл нь 2 хүртэл багцад давхцан ажиллах боломжтой бөгөөд тендерт санал болгосон голлох инженер, техникийн ажилтан, ажилчид, машин механизм, багаж хэрэгсэл нь 3 ба түүнээс дээш багц /хэрэгжүүлэх эрх авсан тендер, гэрээ/-давхардсан тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>22. Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн цахим хэлбэрт оруулж ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод, уншигдахуйц, бичиг хэргийн стандарт шаардлага хангасан байх шаардлагатай. Хэрэв тод биш, уншигдахааргүй тендерийн материал ирүүлсэн бол иж бүрдэл дутуу гэж үзэн тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>23. Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон захиалагчаас тогтоосон үе шатны хуваарьт заасан хугацаанд багтаан зураг төсвийн дагуу чанарын өндөр түвшинд тухайн ажлыг гүйцэтгэн дуусгаж хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.</p> <p>Дээрхи нэмэлт материалуудаас нэг буюу хэд хэдэн баримт бичиг нотлох баримт ирүүлээгүй, эсвэл шаардлага хангахааргүй, баталгаажилтгүй ба зөрчил бүхий хуурамч нотлох баримтууд ирүүлсэн, сүүлийн 2 жилд нийлүүлсэн бараа, ажил, үйлчилгээний чанар хангалтгүй байсан нь өмнөх захиалагч байгууллагуудын тодорхойлолтоор болон хяналт шалгалтын байгууллагын хяналтаар нотлогдсон зэрэг тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТӨОЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p><i>Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар өөрийн ААН-ийн нэвтрэх нэр нууц үгийг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF) файлаар илгээнэ. Цахим тендер шалгаруулалт</i></p>

	<p><i>зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 /тавин мянга/ төгрөгийг www.tender.gov.mn сайтад нэвтэрч төлбөр төлөх хэсэгт банкны e-меркантийн системийг ашиглан төлнө.</i></p> <p>Байгууллагын хаяг: Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны алба, Утас: 70388848, 70388821 , 70388849 , 95490203</p> <p>Давхар болон өрөөний дугаар: Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын “А” байрны 1-р давхар, Ил тод байдлын танхим.</p> <p>Огноо: 2019 оны 1 дүгээр сарын 29-ны өдөр</p> <p>Цаг: 11 цаг 00 минутаас өмнө</p>
ТӨӨЗ 2.2	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p><i>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn сайтын серверийн цагаар тооцогдох тул тендер хүлээн авах хугацаанаас хоцорсон тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</i></p> <p>Байгууллагын хаяг: Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны хэлтэс, Утас: 70388848, 70388821 Факс: 70388849</p> <p>Давхар болон өрөөний дугаар: Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын “А” байрны 1-р давхар, Ил тод байдлын танхим.</p> <p>Огноо: 2019 оны 1 дүгээр сарын 29-ны өдөр</p> <p>Цаг: 11 цаг 20 минут</p>
ТӨӨЗ 3.1	<p>Тендерт оролцох зааварчилгааны дагуу оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах баримт бичгээс бүрдэнэ:</p> <p>а/ Үнийн санал</p> <p>б/ Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь</p> <p>в/ ТӨӨЗ 1.4-д заасан баримт бичиг, нотлох баримт</p> <p>г/ Санхүүжилтийн хуваарь</p> <p>д/ Тендерт оролцогчийн санал болгосон ажлын зураг, төсөв, тухайн ажлыг гүйцэтгэх аргачлал, үе шатны ажлын үнлэгдсэн хуваарь , ашиглах тарьцны техникийн тодорхойлолт, эрх бүхий байгууллагаас 2017 онд олгосон тохиролын гэрчилгээ</p> <p>е/ Тухайн ажлыг дэвшилтэт технологи, шинэ материалаар захиалагчийн тооцсон төсөвт өртөгт багтаан гүйцэтгэх талаарх тендерт оролцогчийн санал</p> <p>ё/ ТӨӨЗ-ийн 1.1-д заасан баримт бичиг</p>
ТӨӨЗ 5.1	Тендер хүчинтэй байх хугацаа: 45 хоног
ТӨӨЗ 7.3	<p>Тендерийн үнийг харьцуулахдаа “дотоодын давуу эрхийн зөрүү” тооцно. Дотоодын давуу эрхийн зөрүү тооцоход тендерт оролцогч дараах шаардлагыг хангасан баримт бичиг нотлох баримтыг ирүүлнэ. Үүнд: Тендерт оролцогч нь давуу эрх тооцуулах хүсэлт хүсэлт ирүүлэх бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйл, Засгийн газрын 2011 оны 103, 2014 оны 18 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 онд баталсан давуу эрх тооцох аргачлалын нөхцлийг хангаж буйг нотлох баримтыг тендерийн бүрэлдхүүнд тусгай хэсэг болгон ирүүлнэ. Дотоодын давуу эрх тооцуулахаар санал болгосон мэргэжилтэй ажилчид, инженер техникийн ажилтнуудын нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн тендерт оролцогч өөрөө төлсөн байх бөгөөд ажилтнуудын нийгмийн даатгал төлсөн болохыг нийгмийн даатгалын байгууллагын НД№07, НД№08 маягт болон ажилтны нийгмийн даатгалын дэвтрийн эх хувиас татсан хуулбарыг тус тус тендерт хавсарган ирүүлнэ.</p>


	Жич: Тендерт оролцогч албан хүсэлт, нотлох баримт ирүүлээгүй бол давуу эрх тооцохгүй. /Дотоодын давуу эрхийн зөрүү тооцохгүй тохиолдолд хаалтанд бичсэн хэсгийг өгөгдлийн хүснэгтээс хасч бичнэ./
ТӨОЗ 8.1	Гэрээ байгуулах эрх олгосон тухай болон тендерт шалгараагүй тухай мэдэгдлүүдийг http://www.umch-tender.kh.gov.mn болон http://www.tender.gov.mn сайтад нийтэлж, оролцогчийн мэйл хаягаар илгээх тул тендерт оролцогч тендерт шалгарсан болон шалгараагүй мэдэгдлийг энд заасан мэдээллийн хэрэгслээс үзэж мэдээлэл авах үүрэгтэй. Мэдэгдлийн эх хувийг баталгаат шуудангаар илгээнэ.

**ОЙЖУУЛАЛТЫН АЖЛЫН ДААЛГАВАР, ШААРДЛАГАТАЙ
МАТЕРИАЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

Үндэслэл шаардлага: Ойг нөхөн сэргээх арга хэмжээ нь “Төрөөс ойн чиглэлээр баримтлах бодлого”, аймгийн Засаг даргын 2016-2020 он хүртэлх үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээ юм.

<p align="center">ОЙЖУУЛАЛТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГАД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА</p>	<ul style="list-style-type: none"> ➢ Мод үржүүлэг, ойжуулах, ойг нөхөн сэргээх чиглэлээр мэргэжлийн /тусгай зөвшөөрөл/ эрхтэй байх ➢ Мод үржүүлэг, ойжуулах, ойг нөхөн сэргээх чиглэлээр ажил гүйцэтгэх туршлагатай инженер техникийн ажилтантай байх ➢ Мод үржүүлэг, ойжуулах, ойг нөхөн сэргээх зориулалтын багаж тоног төхөөрөмжтэй байх ➢ Орон нутагт ургуулсан, ойг нөхөн сэргээх тарьц суулгацны нөөцтэй байх.
<p align="center">ОЙЖУУЛАЛТЫН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ ГАЗРУУД, ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН АГУУЛГА ҮЕ ШАТУУД</p>	<p>Цагаан-Уул сумын нутагт 21.5 га талбайд ойжуулалтын ажил гүйцэтгэнэ.</p> <p>Ойжуулалтын ажлыг доор дурдсан үе шатуудаар зохион байгуулна.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Ойжуулах талбайг сумын ЗДТГ, Ойн ангитай хамтран сонгох; ➢ Ойжуулалтын ажилд ашиглах багаж, тоног төхөөрөмж, тарьц суулгацыг бэлтгэх; ➢ Ойжуулалтын ажлыг зохион байгуулах; ➢ Ойжуулалтын ажлын тайлан боловсруулах гэсэн үе шатуудтайгаар гүйцэтгэнэ.
<p align="center">БЭЛТГЭЛ АЖИЛ</p>	<p>Ойжуулалт хийх газрыг судлах, ойжуулах талбайн зургийг сум дундын ойн ангиар үйлдүүлэх</p> <p>Ойжуулалтын ажилд хэрэглэгдэх шинэ техник тоног төхөөрөмжүүд дээр ажиллах сургалтанд ажилчдыг хамруулж, дадлагажуулах</p> <ul style="list-style-type: none"> • Ойжуулалт хийх, мод тарих, хамгаалах талаар орон нутгийн иргэдэд зориулсан сурталчилгааны тараах материал бэлтгэх <p>Ойжуулалтын ажлыг зохион байгуулах нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан төслийн менежерээр батлуулсан байх</p> <p>Ойжуулалтын ажилд ажиллах ажилчдад ажил гүйцэтгэх технологи болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар зааварчилгаа бэлтгэн өгч, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар анхааруулга өгсөн байх.</p> <p>Ажлын цагийн бүртгэл хөтөлөх загвар бэлтгэсэн байх</p>
<p align="center">ОЙЖУУЛАЛТЫН АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ</p>	<ul style="list-style-type: none"> • Ойжуулалтын ажлыг төслийн менежерээр батлуулсан ажлын төлөвлөгөөний дагуу тухайн жилийн цаг уурын нөхцөл байдалтай уялдуулан 5-р сарын 01-аас 5-р сарын 25-ны дотор багтаан гүйцэтгэнэ.

	<ul style="list-style-type: none"> • Ойжуулалтын ажлыг батлагдсан заавар, схем технологийн дагуу гүйцэтгэсэн байна. • Ойжуулалтын ажилд стандартын шаардлага хангасан 1,2-р зэрэгт хамаарах орон нутагт ургуулсан гарал үүсэл нь тодорхой шинэс модны тарьц суулгацыг ашиглана. • Нэг га талбайд суулгах тарьц суулгацын тоо хэмжээ 2500 ширхэгээс багагүй байна. • Ойжуулсан талбай дахь тарьц суулгацын амьдралт ургалт намрын тооллогоор 75 % дээш ургалттай байхаар арчилгаа нөхөн тарилтын ажил хийсэн байна.
<p style="text-align: center;">ТАЙЛАН БОЛОВСРУУЛАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА</p>	<ul style="list-style-type: none"> • Ойжуулалтын ажлын тайланг цахим хэлбэрээр ойжуулсан талбайн ship file-ын хамт 1 хувь, хэвлэмэл хэлбэрээр 3 хувийг ирүүлнэ. Тайлан дараах бүрдэл хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд: “Ойжуулалтын ажлын тайлан”-д <ul style="list-style-type: none"> ➢ ойжуулалтын ажил гүйцэтгэсэн бүрэлдэхүүн ➢ ойжуулалтын ажил гүйцэтгэсэн газрын танилцуулга, сум орон нутгаас гаргасан шийдвэр, хамтарч ажилласан байдал ➢ ойжуулалтын ажил эхлүүлсэн, дуусгасан, он, сар өдөр, ойжуулсан талбайг хүлээж авсан ажлын хэсгийн акт ➢ ойжуулалт хийсэн тарьц суулгацын талаарх мэдээлэл, ойжуулалт хийсэн схем, ашигласан багаж төхөөрөмж ➢ ойжуулсан талбайг тусгаарласан технологийн карт боловсруулсан тухай ➢ арчилгаа нөхөн тарилт, ойжуулсан талбайн хамгаалалт, ойжуулсан талбай дахь тарьц суулгацын ургалтын талаар дэлгэрэнгүй мэдээллүүдийг бичиж фото зургаар баталгаажуулсан байна.



ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ¹

	Захиалагчаас өгөх ажлын даалгавар, хийх ажлын нэр	Хугацаа
Бэлтгэл ажил	Талбайг тусгаарлаж, тэмдэгжүүлэх, технологийн карт боловсруулж батлуулах	05/Ү
	Ойжуулах талбайг цэвэрлэх, талбар гаргах, чиг тэмдэг тавих	05/Ү
	Ойжуулах, мод тарих, арчилж хамгаалах талаар орон нутгийн иргэдэд зориулсан мэдээлэл, сурталчилгаа хийх	10/Ү
	Ойжуулах талбайг хамгаалах орон нутгийн шийдвэр гаргуулсан байх	10/Ү

	Суулгах материалыг ачих буулгах, түр хадгалах.	10/У
Үндсэн ажил	Суулгах материалыг тарилтанд бэлтгэх.	11/У
	Баталгаажуулсан технологийн картын дагуу ойжуулалт хийх, арчлах.	12/У
Арчилгаа, нөхөн тарилт хийх.	Ургах чадваргүй болсон тарьц, суулгацыг ухаж авах, нөхөн тарилт хийх.	Хавар, намар
	Ойжуулах талбайд мал бэлчээх, мод бэлтгэхийг хориглосон анхааруулга бүхий самбар байрлуулах.	20/У
	Ойжуулсан талбайд цаашид арчилгаа нөхөн тарилт хийх, хамгаалах ажлыг сумын Засаг даргатай гэрээ байгуулан хамтран зохион байгуулах	3 жил
Тайлан бичих	Ойжуулалтын ажлын гүйцэтгэлийн тайлан бичиж, ажлын хэсэгт ойжуулсан талбайг хүлээлгэн өгөх	25/IIIV

1.Ойжуулалтын талбайг сонгох: Ойжуулалт хийх газрыг сонгохдоо 2012 оны "Ой зохион байгуулалтын ажлын" зураг дээр тэмдэглэгдсэн хэсэглэлийн дугаарын дагуу хийж гүйцэтгэнэ. Иймээс кадастрын зураг үйлдэх шаардлагагүй гэж үзэж байна. Ой зохион байгуулалтын зураг дээрх газрын байршил, цэг тэмдэг өөрчлөгдөөгүй бөгөөд ойжуулах талбайн тойм зургийг сум дундын ойн ангиар үйлдүүлэн хавсаргав.

2.Ойжуулалтын талбайг тусгаарлах: Сум дундын ойн анги нь ойжуулалтын талбайг тусгаарлахдаа 0,3 буюу түүнээс бага өтгөрөлтэй, 30⁰ бага налуутай, зүүн болон хойд зүгт харсан байрлалтай, хад асга бага, мод бэлтгэсэн болон ой хээрийн түймэр, өвчин хортонд нэрвэгдсэн, байгалийн сэргэн ургалт муутай талбайг сонгоно. Сонгосон талбайн эргэлтийн өнцөг бүрт шон зоож шонгийн хооронд 50м тутамд пишк мод зоож тэмдэгжүүлсэн байна. Ойжуулахаар сонгосон талбайн зургийг GPS багажаар цэгүүдийг авч, QGIS программ дээр зурна.

3. Ажил гүйцэтгэх төсөв: Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, сангийн сайдын хамтарсан 2013 оны А-368/302 тоот тушаалаар 1 га талбайд гүйцэтгэх ажлын нормативыг 695,000 төгрөгөөр баталсан байдаг ба 21.5 га талбайд ойжуулалтын ажил гүйцэтгэхэд 14,942,500 төгрөгийн зардал гарах тул төсөв хийх шаардлагагүй гэж үзэж байна.

4.Захиалагчийн хяналтын зардал: Захиалагчийн хяналтын зардлыг ойжуулалтын ажилд хяналт тавих төслийн багийн унаа, томилолт, ойжуулалтын ажил гүйцэтгэх талбайг сонгох, зураг үйлдэхэд гаргах зардлаар тооцож гэрээнд тусгана.

Ойжуулалт хийх талбайн байршил

№	Сумын нэр	Газрын нэр	Ойжуулах талбайн хэмжээ /га/-р	Хэсэглэлийн дугаар	Зардал /сая.төг/
1	Цагаан-Уул сум		21.5		14.942.500

Ажлын даалгавар боловсруулсан:

Ойн албаны мэргэжилтэн

Хянасан: БОАЖГ-ын Ойн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Зөвшөөрсөн : БОАЖГ-ын дарга

Танилцсан:

Аймгийн ХОХБТХ-ийн мэргэжилтэн



Б.Уржинсүрэн

Б.Уржинсүрэн

Х.Хадбаатар

Х.Хадбаатар

Р. Жаргалсайхан

Ё.Батсайхан

Ё.Батсайхан

№	Сумын нэр	Нэг талдаа /км/	Хоёр талдаа /км/	Зарцуулах бензин /л/-р	Нэгжийн үнэ /мян.төг/	Нийт үнэ
1	Төслийн багийн ажлын гүйцэтгэлд хяналт тавих					
2	Төслийн багийн ажлын гүйцэтгэлийг хүлээж авах					

Долоо.ЖИШИГ МАЯГТ

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. **Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх**
 - 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.
2. **Төслийн менежерийн шийдвэр**
 - 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.
3. **Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх**
 - 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.
4. **Аюулгүй байдал**
 - 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
 - 4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.
5. **Зааварчилгаа**
 - 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй
6. **Маргааныг шийдвэрлэх**
 - 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.
7. **Ажлын хөтөлбөр**

Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

 - 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
 - 7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.
8. **Зөрчил, гологдол илрүүлэх**
 - 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.
9. **Зөрчил, гологдол арилгах**
 - 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа² дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
 - 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
10. **Зөрчил, гологдол**
 - 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

² Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

арилгахгүй
байх

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги³ төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

³ Алдангийг хэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэхгүй.

- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
 - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
 - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
 - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
 - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ⁴

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: Ойжуулалтын ажил гүйцэтгэх гэрээ, ХӨАОНӨГ/202012077.4.2.1
ГЕН 2.1	Ажил нь захиалагчийн Ажлын даалгавраас-ээс бүрдэнэ. Ажлын талбай нь захиалагчийн баталсан ажлын даалгаварт байгаа газарт байршина
ГЕН 3.1	Төслийн багийг Засаг даргын захирамжаар томилно.
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр 2019 оны 05 сарын 01 өдөр Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр 2019 оны 5 дугаар сарын 25-ны дотор дуусгаж төслийн менежерт хүлээлгээж өгнө
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гарган захиалагчид ирүүлнэ.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа 3 жил байна. Үүнээс: Ажил хүлээн авсанаас хойш сум гүйцэтгэгч байгууллага хоёр гэрээ байгуулан ойжуулсан талбайн хамгаалалтыг сумын Засаг даргын Тамгын газар, ойжуулсан талбайд нөхөн тарилт хийх ажлыг гүйцэтгэгч байгууллага тус тус хариуцна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0,1 хувь байна. ⁵ Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 10 хувь байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлага, гүйцэтгэлийн зургийг 2019 оны 05 сарын 20-ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ Гэрээний үнийн дүнгийн 1 хувь байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын 0 хувь -иар тооцно. Чанарын баталгааны барьцаа хөрөнгийг гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээгээр 1 жилийн туршид захиалагчийн дансанд байршуулна. Ойжуулсан талбайд тарьсан тарьцны амьдралт 75 хувьд хүрээгүй тохиолдолд захиалагч ойжуулалтын ажлыг хүлээн авахаас татгалзана. Захиалагчийн хяналтын зардал нь гэрээний үнийн дүнгийн 2 хувь байна. Гүйцэтгэгч ажил эхлүүлэх зөвшөөрлийг захиалагчаас авах ба ойжуулалтын ажлын үе шат бүрийн ажлын гүйцэтгэлийг төслийн багт хянуулж, ил далд ажлын акт үйлдэж захиалагчаар батлуулна. Тарьц, суулгацийн гарал үүслийн гэрчилгээ, тарьц суулгацийн чанар стандартыг тарилт хийхээс өмнө захиалагчийн төслийн багт танилцуулж акт үйлдэн захиалагчаар батлуулна. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дахь заалтын дагуу нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу мэдээлснийг гэрчлэх баримтыг төслийн багт ирүүлнэ.

⁴

Захиалагчтендерийнбаримтбичгийгтараахаасөмнөгэрээнийтусгайнөхцөлийгбүрэнбөглөсөнбайна.Захиалагчийнгаргаххуваарь, тайланггэрээнийтусгайнөхцөлдхавсаргана.

⁵ Ажлыгхэсэгхэсгэрдүүсгахболонхэсэгбүрталдангхэрэглэхболэндтусгана.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № *[Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]*

Хөвсгөл аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20... онд: _____ төгрөг; 20... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20... онд: _____ төгрөг; 20... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20... онд: _____ төгрөг; 20... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай/_____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны ____ дугаар сарын ____-ны өдөр эхэлж, _____ оны ____ дугаар сарын ____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;

- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

- 6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.
- 7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.
- 8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
- 9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]